



Удирдах ажилтны зөвлөгөөн – 2022

“Сувилахуйн тусламж үйлчилгээний
өнөөгийн байдал, олон улсын чиг
хандлага”

ЭМГ-ын ЭТҮХ-ийн сувилахуйн тусламж
хариуцсан мэргэжилтэн А.Мөнхтуяа

Х.Шаравын нэрэмжит БОЭТ-ийн Сувилахуйн
албаны дарга Ц.Мөнхдэлгэр

2022 оны 04 сарын 07 - ны өдөр





Дэлхийн сувилахуйн байдлын тайланд (2020) сувилахуйн салбар нь эрүүл мэндийн салбарын хамгийн том мэргэжлийн бүлэг бөгөөд эрүүл мэндийн салбарын бараг 60 хувийг эзэлдэг болохыг баталж байна.

Дэлхийн эрүүл мэндийн ажиллах хүчин нь **28 сая** орчин хүн, үүнээс 19 сая гаруй сувилагч, эх баригч багтдаг. (ДЭМБ)

Монгол улсад **2020 оны байдлаар** улсын хэмжээнд эрүүл мэндийн салбарт нийт **56,5** мянган ажиллагчид ажиллаж байна. Үүнээс **13112** нь сувилагч бөгөөд нийт сувилагч нарын 90%-ыг эмэгтэйчүүд эзэлдэг. (Эрүүл мэндийн үзүүлэлт 2020)

Сувилахуйн болон эх барихуйг хөгжүүлэх дэлхийн стратегийн чиглэл / 2021-2025/



”Сувилахуйн болон эх барихуйн дэлхийн стратегийн чиглэл 2016-2020” тайлангаас гарсан зөвлөмж, дэлхийн сувилахуйн нотлох баримтаас үндэслэн боловсруулсан.


- ДЭМБ-ын Сувилахуйн болон дэлхийн стратегийн чиглэл (2021-2025) баталсан бөгөөд энэ нь улс орнуудад сувилагч нараа бүх нийтийн эрүүл мэндийн хамралт болон хүн амын эрүүл мэндийн бусад зорилтод хүрэхэд хувь нэмрээ оруулахад нь туслах бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон.



Стратегийн тэргүүлэх чиглэл:

- 1) Чанартай боловсрол олгох, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг хангах чадвартай эх баригч, сувилагч бэлтгэх
- 2) Ажлын байр бий болгох, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, эх баригч сувилагч нарыг тогтвортой ажиллуулах шаардлагатай.
- 3) Эрүүл мэнд, эрдэм шинжилгээний чиглэлээр сувилахуйн болон эх барихын манлайллыг бэхжүүлэх системүүд
- 4) Эх баригч, сувилагч нарыг дэмжих, хүндэтгэх, хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж хэрэгслээр бүрэн хангах, аюулгүй байдлыг ханган ажиллах

Сувилахуй эх барихуйн 2021-2025 оны тэргүүлэх чиглэл:



Сувилахуйн тусламж үйлчилгээнд баримтлах бодлогын баримт бичиг, тушаал, стандарт, удирдамж :



ЭМСС-н 2016 оны 02 сарын 23-ны өдрийн албан бичиг “ **Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах** ” тушаал хүргүүлэх тухай

- I. “**Дүрэм чиг үүрэг батлах тухай** “- 495 тоот тушаал “Сувилахуйн , эмнэлэгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний удирдлага зохион байгуулалт, сувилахуйн албаны, үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм”
- II. “**Заавар батлах тухай** “- 496 тоот тушаал “Насанд хүрэгчдэд, хүүхдэд хийгдэх сувилахуйн тусламж үйлчилгээний зарим түгээмэл үйлдлийн заавар”
- III. “**Журам батлах тухай** “- 497 тоот тушаал “ Сувилахуйн тусламж үйлчилгээнд үйл ажиллагааны 5 шатлалыг хэрэгжүүлэх журам, үйлчлүүлэгчийн биеийн байдалыг сувилагч үнэлэх , нэмэлтээр хэрэглэх зарим онош тодорхойлолт”



□ **ЭМС-н 2019 оны 04 сарын 15 –ны өдрийн А/183 тоот тушаал**

“Элэгний хатуурлын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний заавар”

□ **ЭМС-н 2017 оны 01 сарын 26-ны өдрийн А/41 тоот тушаал**

“Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний журам”

□ **ЭМС-н 2019 оны 02 сарын 15-ны өдрийн А/71 тоот тушаал** *“Томуу, томуу төст өвчний үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний заавар” батлах тухай*

□ **Өмнөговь аймгийн ЭМГ-н 2018 оны 08 сарын 29-ны өдрийн тушаал**

“Сувилахуйн тусламж үйлчилгээний хяналтын хуудас” батлах тухай

□ **Зонхилон тохиолддог эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний удирдамж** – / Нийслэлийн ЭМГ-с гаргасан- 2017/

I. Эх, хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж , үйлчилгээний удирдамж

II. Насанд хүрэгчдэд үзүүлэх сувилахуйн тусламж , үйлчилгээний удирдамж

III. Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж , үйлчилгээний удирдамж

IV. Яаралтай тусламж үйлчилгээний үеийн сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдамж



- **ЭМС-н 2017 оны 10 сарын 04-ны өдрийн А/381 тоот тушаал**
“Сувилахуйн төвийн үйл ажиллагааны журам” батлах тухай
- **ЭМС-н 2012 оны 01 сарын 03-ны өдрийн 01 тоот тушаал**
“Настны сувилахуйн удирдамж”-г батлах тухай
- **ЭМСС-н 2016 оны 01 сарын 29 –ны өдрийн 29 тоот тушаал**
“Хорт хавдрын хими эмчилгээний үеийн сувилахуйн тусламж , үйлчилгээний заавар “
- **ЭМСС-н 2015 оны 08 сарын 26 өдрийн 329 тоот тушаал**
“Хөнгөвчлөх тусламж , үйлчилгээ үзүүлэх журам , заавар “
батлах тухай
- **ЭМС-н 2017 оны 01 сарын 26 өдрийн А/40 тоот тушаал**
“Сувилахуйн судалгааны ажлын тэргүүлэх чиглэл батлах тухай”
- **MNS 4621-2008 стандарт : “Эмчилгээ , оношлогооны түгээмэл үйлдлүүд”**

Сувилагчийн эмнэл зүйн ур чадварын шатлал боловсруулалт :



Монгол улсын Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ЖАЙКА олон улсын байгууллагуудтай хамтран “ **Монголын сувилагчийн эмнэл зүйн ур чадварын шатлалыг боловсруулах**” сургалтыг улсын хэмжээнд 2 сарын 7-9 ний өдрүүдэд зохион байгуулагдсан.

Оролцогчид:

Улсын хэмжээний ЭМБ-уудын сувилахуйн сургуулийн багш нар,сувилахуйн мэргэжилтнүүд, сувилахуйн албаны дарга нар, арга зүйч сувилагч нар




Цөм чадамж гэдэг нь? / Ур чадварын /


Нийгмийн эрэлт хэрэгцээнээс үүдэн бий болох мэдлэг, ур чадвар, үнэ цэнэ, хандлага тэдгээрийн цогц болох *Аливаа өөрчлөлтийг мэдрэх чадвар нь эрүүл мэндийн ажилчдын эзэмших ёстой чадвар юм.*

Чадамжид суурилсан боловсрол гэдэг нь?

Өмнөх сургалтын агуулга:



Цөм чадамжинд суурилсан анагаах ухааны боловсролын агуулга





Сувилахуйн практик ур чадварын гол цөм болох 4 чадвар

Сувилахуйн гол цөм практик чадвар:

Сувилагчийн ёс зүйг чандлан баримтладаг, сувилахуйн үнэн зөв ур чадварт тулгуурлан үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагат нийцүүлэн газар дээр нь сувилахуйн тусламж үзүүлэх чадвар

1. Шийдвэр гарахад туслах чадвар: Үйлчлүүлэгч (эмчилгээ, амьдарлын төгсгөлөө үдэж буй өвчтөн г.м)-д өөрөөр нь сонголт хийлгэх үүднээс шийдвэр гаргахад

2. Эрэлт хэрэгцээг олж харах чадвар: Сувилахуйн арга барилыг тогтоож, үйлчлчлүүлэгчид тохирсон стратегийг сонгох

3. Хамтран ажиллах чадвар: Үйлчлүүлэгчийг голчилсон мэдээ мэдээлэлийг бусад мэргэжилтнүүдтэй хуваалцаж, сувилахуйн чиг барилыг хэлэлцэж хамтраг ажиллах

4. Сувилах чадвар: Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлж үнэлгээ хийх

Х.ШАРАВЫН НЭРЭМЖИТ БОЭТ-ЫН СУВИЛАГЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНҮҮД



Аймгийн ЭМГ-ын дэргэдэх Сувилахуйн албаны бүтэц бүрэлдэхүүн:



ЭМГ-н даргын 2021оны 02 сарын 22-ны А/10 тушаал “ Сувилахуй, эмнэлэгийн тусгай мэргэжлийн алба томилох тухай”

Албаны дарга: А.Мөнхтуяа / ЭМГ-ын сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн /

Гишүүд: Ц.Цэвэлмаа /БОЭТ-ийн эх баригч/
Г.Цэрэндаваа /БОЭТ-ийн сувилагч/
Д.Мөнхчулуун /БОЭТ-ийн ариутгагч/
Ц.Мөнх-оргил /БОЭТ-ийн лаборант/
Д.Батцэцэг /Энхийн хүслэн ӨЭМТ-н арга зүйч сувилагч/
М.Майнбаяр /Өнө-Орших ӨЭТ-н арга зүйч сувилагч/
Б.Цэцэг-Эрдэнэ /Цогт-Овоо сумын ЭМТ-н багийн бага эмч/
А.Дэлгэрцэцэг /Ханбогд ЭМТ-н арга зүйч сувилагч/

Нарийн бичгийн дарга : У.Ууганцэцэг /БОЭТ-ийн эм найруулагч/



БОЭТ-ын сувилахуйн албаны бүтэц бүрэлдэхүүн:

Сувилахуйн албаны дарга: Ц.Мөнхдэлгэр

БОЭТ-ийн Ахлах сувилагчид:

- 1) Дотор, хөнгөвчлөх, харшлын тасаг- Г.Мажигсүрэн
- 2) Эрчимт эмчилгээ- С.Цэцэгсүрэн
- 3) Яаралтай түргэн тусламж- О.Баасанжаргал
- 4) Мэс засал- Т.Түмэндэлгэр
- 5) Гэмтэл- Г.Ариунзаяа
- 6) Мэдрэл,сэтгэц, уламжлалт – Т.Доржханд
- 7) Нярай судлал-Ц.Отгонбаяр
- 8) Хүүхэд- П.Хишигмаа
- 9) Зөвлөх поликлиник- Н.Эрдэнэчулуун
- 10) Нэгдсэн лаборатори- М.Сарантуяа
- 11) Халдварт,сүрьеэ- А.Болормаа
- 12) Дүрс оношилгоо- Б.Сэндэр
- 13) Төрөх, эмэгтэйчүүд- Б.Байгалмаа



Хүний нөөцийн судалгаа:

Батлагдсан орон тоо:

- Сувилагч- $93+95=188$
- Эх баригч- $21+14=35$
- Тусгай мэргэжилтэн- $65+29=94$

НИЙТ-285

Одоо ажиллаж байгаа:

- Сувилагч- $70+75=145$
- Эх баригч- $17+18=35$
- Тусгай мэргэжилтэн- $55+29=84$

НИЙТ-264

Судалгааг дүгнэхэд БОЭТ-20 Сум,өрхийн ЭМТ-д -23 **Нийт- 43**

Тусгай мэргэжилтэн 10

Батлагдсан орон тооноос Нийт- $43+10= 53$ дутуу ажиллаж байна.



АЖЛЫН ТУРШЛАГА, АЖИЛЛАСАН ЖИЛ:

- 1-5 жил- $25+25=50$
- 6-10 жил- $36+28=64$
- 11-15 жил- $20+20=40$
- 16-20 жил – $10+5=15$
- 20-с дээш жил- $52+38=90$

Судалгааг дүгнэхэд:

10-с дээш жил ажилласан 58,9%-г эзэлж байгаа нь ажлын туршлагатай сувилагч тусгай мэргэжилтэн харьцангуй олон байгааг, 20-с дээш жил ажилласан нь 34.7%-г ирээдүйд хүний нөөцийг бэлтгэх шаардлагатайг харуулж байна.



Боловсролын байдал:

- I. Диплом- $53+53=106$
- II. Баклавар- $81+49=130$
- III. Магистр- $3+10=13$

Судалгаанаас харахад сувилагчдын 89,6% нь баклаварын боловсролтой байгаа нь харагдаж байна.

Мэргэжлийн зэрэгтэй сувилагч:

- I. Зөвлөх-1
- II. Тэргүүлэх- $2+19=21$
- III. Ахлах- $25+14=39$

Мэргэжлийн зэрэгтэй сувилагч 61 байгаа нь нийт сувилагчдын 42,5%-г эзэлж байна.



Шагнал урамшуулал:

- I. Алтан гадас одон – $4+4=8$
- II. Хөдөлмөрийн хүндэт медаль- $14+9=23$
- III. ЭХТА- $68+42=110$
- IV. ЭМЯ-ны хүндэт жуух бичиг – $72+66=138$

Монголын сувилагчдын нийгэмлэгийн шагнал:

Ард түмний талархал хүлээсэн “Гавьяат сувилагч ” цол тэмдэг

- I. БОЭТ-ын мэс заслын сувилагч – Б.Байгалмаа
- II. Сувилахуйн албаны даргаар ажилласан ахмад сувилагч
П.Дэлгэрцэцэг
- III. БОЭТ-ын мэс заслын сувилагч – Ё.Алтанцэцэг



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/03

Даланзадгад

Сувилахуй, тусгай мэргэжлийн тусламж
үйлчилгээг хөгжүүлэх 2022 оны аймгийн
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 заалтыг үндэслэн, хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Сувилахуй, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх 2022 оны аймгийн төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын болон орон нутгийн төсөв, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын хандив тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цэндсүрэн), эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Ж.Отгонбайгал), Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (А.Мөнхтуяа) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Б.Мидэрсүрэн)-д даалгасугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Үйл ажиллагааны чиглэл:

1. Нийгмийн эрүүл мэнд
2. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах
3. Сувилахуйн хүний нөөцийг нэмэгдүүлэх, ажлын ачаалалыг тэнцвэржүүлэх
4. Сувилахуйн тусламж үйлчилгээний удирдлага зохион байгуулалтын тогтолцоог бэхжүүлэх

Үйл ажиллагааны Нийт - 4 чиглэл бүхий
42 ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхээр
ажиллаж байна.

ОУС-ын өдрийг угтсан үйл ажиллагааны төлөвлөлт-2022



Анх Английн иргэн **“Дэнлүү барьсан эмэгтэй”** хэмээн дэлхийд алдаршсан сувилагч, багш Флоренсе Найтенгелийг сувилахуйн ухааныг үндэслэгч гэж үзэн түүний төрсөн өдөр буюу тавдугаар сарын 12-ны өдрийг Олон улсын сувилагчдын нийгэмлэгээс Сувилагч нарын өдөр болгосон.

Монгол Улс сувилагчдын өдрийг 1995 оноос тэмдэглэж ирсэн ба жил бүрийн энэ өдөр сувилагчдын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэн сурталчлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагааг зохион байгуулдаг уламжлалтай.

2022 оныг ЭМЯ-с ОУС-н өдрийг “Сувилагчдын бие даасан байдал-Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал сайжруулъя” уриан дор тэмдэглэхээр зарласан.

Өмнөговь аймаг ОУС-н өдрийг угтсан олон талт үйл ажиллагааг зохион байгууллахаар төлөвлөгөөний төсөлийг гарган бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.

Өвчлөл ажил ачаалалд нөлөөлж байгаа нь



Өвчиний нэршил /ОУӨА-10/	2018	2019	2020	2021
Халдварт ба шимэгчит өвчин	133	206	73	58
Хавдар	108	123	119	86
Цус, цус бүтээх эрхтэний өвчин ба дархын механизм хамарсан эмгэг	34	55	51	34
Дотоод шүүрэл ба тэжээлийн ба бодисын солилцооны эмгэгүүд	161	247	235	139
Сэтгэцийн ба аягийн эмгэг	258	250	218	99
Мэдрэлийн тогтолцооны өвчин	695	676	709	487
Нүд ба түүний дайврын өвчнүүд	58	88	9	2
Чих ба хөхөнцрийн өвчин	14	15	9	5
Цус эргэлтийн тогтолцооны	604	663	574	453
Амьсгалын тогтолцооны өвчин	1236	1316	733	399
Хоол шингээх эрхтэний өвчин	998	1109	985	774
Арьс ба халимын өвчин	191	258	192	128
Яс булчингийн тогтолцооны холбох нэхдэсний өвчин	233	311	201	90
Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин	324	391	434	276
Жирэмслэх, төрөх төрсний дараах үе	1795	1977	731	1984
Төрөх тойрны / перинатал / үед үүсэх зарим оёг	57	44	138	153
Төрөлхийн гажиг хэв гажил, өнгөтцогцсын гажуудал	43	14	5	1
Бэртэл,хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	499	546	593	494
Ковид				2887
Бүгд	7441	8289	6009	8549

Тайлбар: 2021 оны өвчлөл 2020 оныхоос 2540 буюу 42%-р өссөн боловч сувилагч тусгай мэргэжилтэн нэмэгдээгүй байна.

Сувилагч, тусгай мэргэжилтний ажилласан илүү цагаар ажилласан байдал:



- Энгийн эмчилгээний тасагт ажилласан 1 сувилагчийн илүү цаг 208 /24 цагаар тулаа хийсэн цаг үүнээс гадна бичигдээгүй 32 цагаар илүү ажиллаж байна. /
- БОЭТ-н “Улаан бүс”-д Ковид-19-н тусламж үйлчилгээний баг 28 удаа ээлжээр орж ажилласан.
- Улаан бүсэд 14 хоног, 7 хоног байрлан 24*48 цагаар ээлжээр ажилласан ба 1 сувилагч дунджаар 528 цаг илүү цагаар ажилласан байна. /Стандарт орон тоогоороо ажиллахад 1 сувилагч 126 цаг ажиллах ёстой /
- Сувилагч мэргэжилтний хомсдолд орсонтой холбоотой сувилагч тусгай мэргэжилтний ажил ачаалал 3 дахин нэмэгдсэн
- Сүүлийн 3 жил шинээр төгсөлт ирээгүй

Цаашид хамтарч хийх ажлуудад дэвшүүлэх санал :



- Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд бодлогоор Эрүүл мэндийн салбарын сувилагчийн хүний нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах
- Аймгийн “Нутгийн хишиг” хөтөлбөрт сувилагч мэргэжилтнүүдийг хөгжүүлэн бэлтгэж ажиллуулах ажлуудыг тусгаж дэмжих
- Сувилагчийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд анхаарах /Гадаад харилцаа сайжруулах/
- Нийгмийн байдалд тусламж дэмжлэг үзүүлэх
- Орон нутгаас тусгай шалгуурт тэтгэлэг нэвтрүүлэн сувилагч нарыг хамруулах.

“Сувилахуйн тусламжийн шинэчлэл-Сувилагч мэргэжлийн үнэ цэнэ” сэдэвт хэлэлцүүлэг



Хэлэлцүүлгийн зорилго:

Сувилахуйн тусламжийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах, сувилагч мэргэжилтний тулгамдсан асуудлыг тодорхойлох

Хэлэлцүүлэг 2 үе шаттай зохион байгуулагдсан.

- I. Орон нутагт- Байгууллага тус бүр дээрээ /Улсын хэмжээнд 68 байгууллагын 830 сувилагч хамрагдсан/
- II. Улаанбаатар хот- “Удирдах ажилтны зөвлөгөөн -2022”

/ 2022.04-05/

Хэлэлцүүлгийн үе шат:



Эхний үе шат:

Өмнөговь аймгийн хэмжээнд 2022.02.25 -ний өдөр ЭМ-н18 байгууллагын 115 сувилагч хамруулан “Сувилахуй тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээ”-нд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлон хэлэлцэж хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтээ нэгтгэж ЭМЯ-нд хүргүүлсэн.

2 дахь үе шат:

ЭМЯ-ны сувилахуйн мэргэжилтэн хэлэлцүүлэгийн санал, дүгнэлт нэгтгэл тайланг ЭМБ-уудын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцуулан **“Сувилахуйн тусламж, хүний нөөц, сувилагчдын нийгмийн тулгамдсан асуудлууд”**-ыг хэлэлцүүлж шийдвэрлэх арга зам, зөвлөмжийг боловсруулсан.

/Нийт-74 хүн хамрагдсан /

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУВИЛАГЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ДУНД

ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГЭЭС ГАРСАН САНАЛЫН НЭГТГЭЛ ТАЙЛАН

Даланзадгад

2022/02/28

Сэдэв: "Сувилахуйн тусламж үйлчилгээний шинэчлэл- Сувилагч мэргэжлийн үнэ цэнэ"

Хаана: Х.Шаравын нэрэмжит БОЭТ-ын хурлын танхимд

Хэлбэр:Танхим болон цахим хослосон

Хугацаа: 2022 оны 02 сарын 25 -ны 14 цагт

Хамрагдсан хүрээ:

Аймгийн БОЭТ,14-н СЭМТ,3-н ӨЭМТ-н сувилагч, тусгай мэргэжилтнүүд

Хэлэлцүүлгийн нэгтгэсэн асуудлууд:

I.Сувилахуйн тусламж үйлчилгээ:

1. Аймгийн БОЭТ-д ажиллах сувилагч, эх баригч, тусгай мэргэжилтний үндсэн орон тоог нэмэгдүүлэх / Нэгдсэн эмнэлэгийн стандарт бүтэц орон тоогоор ажиллаж байна. /
2. СЭМТөвүүдэд ирж ажиллах хүний нөөц дутмаг,нэг сувилагчид ноогдох үйлчлүүлэгчийн тоо их учраас ажлын ачаалал нэмэгдэж 2-3 хүний ажлыг давхар гүйцэтгэж байгаа нь эмнэлэгийн тусламж үйлчилгээг чанарт сөргөөр нөлөөлдөг.
3. Ахлах сувилагчийн үндсэн ажлыг дангаар нь гүйцэтгүүлснээр дотоодын хяналт үнэлгээ сайжирч тусламж үйлчилгээний чанар сайжирна.
4. Сувилахуйн албыг бүтэц орон тоогоор нь ажиллуулах /арга зүйч сувилагчтай байх /
5. Эмчилгээний тасгуудад өдрийн эмчилгээний болон туслах сувилагч ажиллуулах
6. Орон нутгийн эмнэлгүүдэд мэдрэл сэтгэцийн тасаг, халдварт сүрьеэгийн тасаг нь салаагүй хамт үйл ажиллагаа явуулдаг нь ажлын ачаалалыг нэмэгдүүлдэг.
7. Ажил хавсран гүйцэтгэсэн тохиолдолд 40% нэмэгдэл олгодог байх / хэт бага 20% хүртэл, зарим үед олгодоггүй /
8. Физик эмчилгээ, хөдөлгөөн засалч,шавар , профены, бариа заслын сувилагчийн орон тоог нэмэгдүүлж уламжлалт эмчилгээний хэсгийг дэмжин ажиллах
9. Сэтгэцийн сувилагч нарыг хорогдуулсан цагаар ажиллуулах
10. Ажлын байрны аюулгүй байдлыг ханган ажиллуулах талаар бүх шатанд анхаарч ажиллах / цагдаа, харуул хамгаалалтын ажилтантай болох /
11. Хүлээн авах яаралтай тусламжийн хэсэгт эмчилгээний болон бүртгэлийн хэсэгт 2 сувилагч зэрэг ажиллуулах / ажлын ачаалал маш их /
12. Хүүхдийн тасгийг эрчимт эмчилгээний ээлжийн 4 сувилагчтай болгох
13. Сувилагч нарын хөтөлдөг АШМаягт их байгаа нь ажлын ачаалал нэмдэг.
14. Биеийн байдлыг үнэлэхэд хэрэглэгддэг багаж хэрэгсэлийг эмнэлэгийн зориулалтын чанартай шаардлага хангасан төхөөрөмжөөр байнга хангах / өдөр тутамд ашиглагдаж элэгдэл хорогдолд орж байдаг тул /
15. Эмнэлэгийн тусламж үйлчилгээнд ажлын ачаалал их байгаа нь хүлээгдэл түүнчлэн стрессыг нэмэгдэгдүүлж ёс зүйн алдаа гаргахад нөлөөлдөг.
16. Бүх шатны ЭМБ-уудад цахим сүлжээний системийг хурдацтай хөгжүүлж цаасан бичиг баримтыг халж улсын хэмжээнд жигдрүүлэх

II. Сувилахуйн боловсрол :

1. Сувилагч , тусгай мэргэжилтний англи хэл, япон хэлний мэдлэгийг сайжруулахад чиглэсэн сургалтыг тасралтгүй жилийн турш удаан хугацаагаар явуулж баймаар байна. / гадаадад мэдлэг дээшлүүлэх суралцах, туршлага судлах боломж бүрдүүлэх /
2. Сувилагч зөвлөгч, сургагч багш бэлтгэх тусгайлсан ажлуудыг зохион байгуулах / сургуулийн хүүхдүүдэд ЭМ-н хичээл зааж тодорхой хэмжээний цалин хөлс авдаг байх системийг бодлогын түвшинд хийх /
3. Эрдэм шинжилгээний илтгэл бичих талаар сувилагч нарт онолын мэдээлэл олгох сургалтыг ЭМЯ, Мэргэжлийн нийгэмлэг холбоод, ТББ -тай хамтарч явуулах
4. Сувилагч , эх баригч нарын ёс зүйн сургалтыг тасралтгүй явуулах
5. Гадаадад , бусад хот, улсын эмнэлгүүдэд ахлах сувилагч нар болон мэргэжлийн чиглэлээр лаборант , эх баригч , сувилагч нар,шинжилгээний аппарат болон тоног төхөөрөмж дээр ажилладаг хүмүүсийг мөн адил туршлага судлуулах
6. Гадаад болон орон нутгийн сургалтанд суралцахад санхүүгийн дэмжлэгийг аймаг болон ЭМЯ-с дэмжлэг үзүүлдэг байхаар талаар төлөвлөгөөнд тусгуулах
7. Цахим үйлчилгээ нэвтэрсэнтэй холбоотой сувилагч , тусгай мэргэжилтнийг компьютерийн сургалт хамруулах
8. Ахлах сувилагч нарыг удирдлага арга зүйн сургалтанд хамруулах
9. Сувилагчдыг солилцоогоор ажиллуулах
10. Лаборант , техникч нарыг баклаварын болгох боломжийг судлах , шийдвэрлэх / урт,богино хугацааны /
11. Сувилахуйн сургуульд суралцагч оюутнуудыг цалинтай суралцах хууль эрх зүйг бүрдүүлэх
12. Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн 5 жил тутамын тэтгэлгийг 3 жилд олгож байх

III.Сувилахуйн хөдөлмөр эрхлэлт:

1. Сувилагч , тусгай мэргэжилтнүүдийн цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулж цалинг нэмэгдүүлснээр амьдралын баталгаажих түвшин сайжирч тогтвор суурьшилтай ажиллана.
2. Төрөлжсөн ажил мэргэжилүүдийн ажлын ачаалалд дүн шинжилгээ, томоохон судалгааг бодлогын түвшинд хийж ажил олгогч нарт ажлын ачаалалын тэнцвэржүүлэлт хийхэд нь ашиглуулах
3. Ажлын хувцасны хангалт муу
4. Компьютерийн хэрэгцээтэй бүх хэсэгт хангаж нэмэгдүүлэх
5. Амрах алжаал тайлах өрөөг бүх ЭМБ-уудад байгуулах чиглэлийг байгууллагын удирдлага албан ёсоор үүрэг өгөх
6. Олон улсад эх баригч нар эрүүл төрөлтийг хянаж төрүүлдэг ба хувийн эх баригчийн амаржих газрыг монголд хэрэгжүүлэх тусгай зөвшөөрлийг олгох журмыг батлаж хэрэгжүүлэх
7. ЭМБ-уудын удирдлага ажил олгогч, хүний нөөцийн мэргэжилтэнүүд тухайн ажилтны ажил байдлын тодорхойлолтонд ажил үүргийн хуваарь, нэршлийг нарийвчлан оновчтой тусгах
8. Сувилагч , тусгай мэргэжилтнүүдийн амьдрах нөхцлийг сайжруулах орон сууцны асуудлыг шийдвэрлүүлэх , хөнгөлөлтэй зээлд хамрагдах , түрээсийн байр, байрны

урьдчилгаанд зохих хэмжээний дэмжлэг олгох, боломжоор хангах талаар ЭМЯ –с бодлогын түвшинд олон талт ажлуудыг зохион байгуулах

9. Сувилагч , тусгай мэргэжилтнүүдийн ажлын үнэлэмжийг харгалзан үзэж гадаадын орнуудад 2-3 хүнийг жилдээ аялуулж байх
10. Сувилагч,тусгай мэргэжилтэн бэлтгэдэг улсын болон хувийн хэвшлийн сургуулиудын төгссөн сувилагч, тусгай мэргэжилтэнүүдийн мэдээлэл бааз судалгааг үндэслэн ажилгүй байгаа ажиллах сонирхолтой мэргэжилээсээ хөндийрсөн хүмүүстэй холбогдож чадвахжуулах онол, дадлагын сургалтыг зохион байгуулж хүний нөөцийг нэмэгдүүлэх
11. Үр бүтээлтэй амжилт гаргасан , олон жил ажилласан хүмүүсийг амралт сувилалд хөнгөлттэй болон зардлыг дааж амруулах
12. Сувилагч , тусгай мэргэжилтний эрүүл мэндэд анхаарах төрөл бүрийн ажлыг зохион байгуулах
13. Сувилагч нарын ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх тал дээр холбогдох мэргэжлийн байгуулагуудтай хамтарч анхаарч зохих ажлуудыг зохион ажиллаж хэрэгжүүлэх
14. Ээлжийн сувилагч нарыг хоолтой болгох
15. Үр дүн , ур чадварын нэмэгдэлийг хангалттай өгөх хувийг нэмэгдүүлэх
16. Эмнэлэгийн ажилчдын цалингийн зээлийг нэг удаа тэглэж өгөх
17. Ипотекийн зээлэнд эргэн төлөлтийн тооцоололд цалин багатайгаас цалин нь хүрдэггүйгээс орж чаддаггүй.
18. Хүүхэд харах цэцэрлэг ажлын ойр байж эмнэлэгийн ажилчид хүүхдийг хамруулах боломжуудыг судлан хэрэгжүүлэх

IV.Сувилахуйн манлайлал:

1. Бодлогын түвшинд сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд Сувилахуйн алба бие даан шийдвэрлэж байх, эрхийг хангах
2. Аймаг орон нутгийн нийгмийн бодлогын хэлтэст сувилагч мэргэжилтэн ажиллуулах талаар хууль эрх зүйн боломж байгаа эсэхийг судлуулах хүсэлтийг гаргаж байна. /Төр захиргаа, нийгэмд нөлөөлүүлэх/

Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлт: / Зөвлөмж-д оруулах /

1.Сувилахуйн тусламж үйлчилгээ:

Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ЭМБ-уудад батлагдсан орон тоогоор -317, одоо 262 сувилагч, тусгай мэргэжилтнүүд ажиллаж байна.

Үүнээс аймгийн хэмжээнд батлагдсан орон тоогоороо 45-н сувилагч, 10-н тусгай мэргэжилтэний дутагдалтай ажиллаж байгаа нь нэг хүнд ноогдох ажлын ачаалалыг нэмэгдүүлж сувилахуйн тусламж үйлчилгээг чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

- Иймээс хүний нөөцийн дутагдалтай аймгуудад сувилахуйн сургуультай аймгууд болон бусад аймгуудаас гэрээт сувилагч нарыг илгээж ажиллуулах боломж судлуулах, хэрэгжүүлэх
- Сувилагч,тусгай мэргэжилтнүүдийн хөтөлдөг АШМБүртгэл их байдаг нь ажлын ачаалалыг нэмэгдүүлдэг учраас улсын хэмжээнд яаралтай цахим бүртгэлийн системд бүрэн холбуулах

2.Сувилахуйн боловсрол:

- Сувилахуйн төрөлжсөн мэргэжлийг БОЭТ-уудыг түшиглэн орон нутагт бэлтгэх боломжийг судлуулан хэрэгжүүлэх
- Гадаад харилцааг сайжруулан гадаад суралцах, туршлага судлуулах үйл ажиллагаанд орон нутгийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг хамруулах
- Хэлний болон компьютерын сургалтыг эрчимжүүлсэн байдлаар чанартай сургалтуудыг зохион байгуулах

3.Сувилахуйн хөдөлмөр эрхлэлт:

- Өмнөговь аймгийн хувьд уул уурхай хөгжил, хилийн боомтыг дагасан гадаад харилцаатай холбоотой суурин болон явуулын хүн ам их учир цалин ихтэй газар ажиллахаар ажлаас гарч мэргэжлээсээ өөр чиглэлийн ажлыг их сонгодог.
- Ажлын ачаалал ихтэй цалин бага байгаа нь ажлаас халширч ажлаас гардаг.

Иймээс сувилагч,тусгай мэргэжилтний цалингийн шатлалыг ахиулах, нэмэгдүүлэх урамшуулал олгох тал дээр бодлогын түвшинд шийдвэрлүүлэх

4.Сувилахуйн манлайлал:

- Шийдвэр гаргалтанд сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд Сувилахуйн албыг бүрэн бүрэлдэхүүнээр ажиллуулах
- Ахлах сувилагч нарыг орон тоогоор нь ажиллуулах давхар ажил эрхлүүлэхгүй байх
- СА-ны бүрэлдхүүн ахлах сувилагч, арга зүйч нарыг манлайлалын чадваржих сургалтанд хамруулах

Тайлбар:

Сувилахуйн тусламж үйлчилгээнд тулгамдсан асуудлыг тодорхойлон гаргаж ирэх зорилготой хэлэлцүүлгийг ярилцлага,асуумжаар авсан ба хэлэлцүүлэгт **Нийт- 115** сувилагч,тусгай мэргэжилтэн хамрагдсан.

Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэгт БОЭТ-ын захирал, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, хүний нөөцийн албаны дарга нар оролцож сувилахуйн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй асуудлуудыг сонсож зарим нэг асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэж санал санаачлагыг дэмжсэн.

Хэлэлцүүлгээс гарсан санал ,нэгтгэл, дүгнэлтийг ЭМГ-ын удирдлагуудад танилцуулагдсан.

Хэлэлцүүлгийн саналыг нэгтгэсэн :

ЭМГ-ын ЭТҮХ-ын Сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Мөнхтуяа

БОЭТ-ын Сувилахуйн албаны дарга Ц.Мөнхдэлгэр

Сувилагч, тусгай мэргэжилтэнүүдийн хэлэлцүүлэг

16:37

LTE 28%

Close

Participants (9)

Q Search

АвирМөнхтуяа (me)

БОЭТӨМНӨГОВЬ (Host)

H

Номгон

Ө

ӨМА БД ЭМт

Ц

ЦЦ Сум дунд Нандиа

Bayrbaysgalan Baysaa

BE

BOsum EMTuw

T

tsogtowoo

1

TS

Tsogtovoo sum B.TUNGALAG

Invite



САЛБАР ХУРАЛДААН- 3

СУВИЛАХУЙН ТУСЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛ, СУВИЛАГЧ МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭНЭ

Модератор: П.Эрхэмбаяр,Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Сувилахуйн салбар хэлэлцүүлэгт нийт 74 хүн оролцсон ба Төрийн захиргааны удирдлагын газрын дарга П.Эрхэмбаяр нээлт хийж үйл ажиллагааг эхлүүлсэн.

Хэлэлцүүлгийн үеэр Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг нар оролцогчдод хандан нээлтийн үйл ажиллагааны үг хэлж, хэлэлцүүлэгтээ идэвхтэй оролцохыг хүссэн.

- ✓ JCI Mongolia байгууллагаас н.Чинзориг багш Хувь хүний хөгжил сэдвээр лекц
- ✓ ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга П.Эрхэмбаяр “Сувилагчийн төгсөлтийн дараах сургалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр итгэл
- ✓ ЭМЯ-ны Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн Г.Хулан “Сувилахуйн тусламжийн өнөөгийн байдал, олон улсын чиг хандлага” сэдвүүдээр тус тус илтгэл хэлэлцүүлсэн.

Сувилахуйн тусламж үйлчилгээ, хүний нөөц, нийгмийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор оролцогчдыг 8 жижиг бүлэг болгон асуудал дэвшүүлэн хэлэлцүүлсэн.

Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох:

1. Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартыг шинэчлэх
2. Сувилахуйг хөгжүүлэх хөгжлийн бодлого, стратеги боловсруулах
3. Сувилахуйн албаны үйл ажиллагааны журмыг шинэчлэх
4. Сувилагчийн хүний нөөцийн асуудлыг төрөөс бодлогоор дэмжих

Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

1. Нэг сувилагчид ноогдох үйлчлүүлэгчийн тоог багасгах
2. Нэг эмчид ноогдох сувилагчийн тоог 1:2 болгох
3. Туслах сувилагчийг ажиллуулах
4. Сувилахуйн тусламжийн орчин үеийн техник, технологиор хангах
5. E-Health программыг боловсронгуй болгох, анхан шатны бичиг баримтын давхардлыг арилгах
6. Туслах сувилагчийг ажлуулах
7. Эрүүл, аюулгүй ажлын байрны орчин нөхцлөөр хангах
8. Шөнийн ээлжээр ажиллах сувилагчдын ажлын цагийг богиносгох

Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр:

1. Сувилагчдын эмнэл зүйн ур чадварыг сайжруулах
2. Эмнэлэг сургуулийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, уялдаа холбоог сайжруулах
3. Ажлын байранд тасралтгүй сургалтыг зохион байгуулах
4. Сувилагчийн ур чадварыг сайжруулах төв байгуулах
5. Сувилахуйн удирдлагыг удирдахуйн чиглэлээр мэргэшүүлэх, чадавхжуулах
6. Сувилагчийн бие даасан байдлыг бэхжүүлэх, шийдвэр гаргахад тэгш эрхтэйгээр оролцуулах

Сувилагчийн нийгэм хамгааллыг сайжруулах чиглэлээр:

1. Цалингийн шатлал ахиулах
2. Орон сууцанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх
3. Эмнэлгийн дэргэд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хүүхдийн цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв байгуулах
4. Нийгэмд сувилагч мэргэжлийг сурталчлах, мэргэжлийн үнэ цэнийг өсгөх компанит ажлыг зохион байгуулах
5. Сувилагчийн постны тохижилт муу-Постноос үйлчлүүлэгч хянах орчинг бүрдүүлэх, камержуулах
6. Харилцаа хандлага, ёс зүйг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, хандлага өөрчлөх олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах
7. Тоног төхөөрөмжийн хангалт муу тул тухайн эмнэлгийн төсөвт суулгах, батлуулах
8. Тасралтгүй сургалтыг ажлын байран дээр зохион байгуулах, сургалтын орчинг бий болгох, хэрэглэгдэхүүн, хүний нөөц сургагч багшаар хангах
9. Сувилагчийн постноос үйлчлүүлэгч хянах орчинг бүрдүүлэх, камержуулах
10. Эрсдэлийн даатгалд сувилагч нарыг хамруулах
11. Сувилахуйн албадыг орон тоогоор ажиллуулах, сургалт хариуцсан арга зүйчийг ажиллуулах
12. Удирдлагын сургалтанд сувилахуйн мэргэжилтэн, ахлах сувилагч нарыг хамруулах

Хэлэлцүүлгийн үр дүн:



Тус хэлэлцүүлгийн нийт оролцогчдоос гарсан санал, дүгнэлт, зөвлөмжинд үндэслэн ДЭМБ-аас баталж гаргасан Сувилахуй, эх барихуйг хөгжүүлэх дэлхийн стратеги (2021-2025) чиглэлд нийцүүлэн сувилахуйн салбарт хөрөнгө оруулах, сувилагч мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг зохистой хуваарилж, ажлын байранд тогтвортой ажиллуулах, сувилагчийн боловсрол, манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх үндэсний хэмжээний “Сувилахуй, эх барихуйг хөгжүүлэх стратеги”-г боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана.



Сувилагч хүн гэдэг сая төрсөн хүүхдийн уйлах дуунаас эхлээд амьдралын сүүлчийн амьсгал хүртэлх хүний амьдралын бүхий л хугацаанд эрүүл мэндийн тусламж үзүүлэгч, эрүүл мэндийн боловсрол олгодог сургагч багш, өвчтөний өмгөөлөгч, халамжлан хүмүүжүүлэгч, дотны найз болсон эрхэм мэргэжилтэнгүүд билээ.



Анхаарал хандуулсанд баярлалаа